ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймаг дахь Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ОРА-2026/097/НА-СТА-ТШ3


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Орхон аймаг<br>2025 он | Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва<br>Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Б.Буян-Ундрах<br>Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn<br><br>“Төгс нотолгоо аудит” ХХК-ийн ахлах аудитор: Г.Цэцэгмаа<br>Утас: 99889665 Цахим хаяг: tugsnotolgooaudit@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 9826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.02.25 № 82
танай ____________-ны № ____________-т

ОРХОН АЙМАГ ДАХЬ БҮСИЙН
ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРАЛ
Ц.НАРАН-ЭРДЭНЭ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймаг дахь бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймаг дахь бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант оны 12 сарын 31-ны байдлаар төлбөртэй тусламж үйлчилгээний эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэлийн санхүүжилтийн авлага 3,937,523.1 мянган төгрөг, эм, эмнэлгийн хэрэгсэл урвалж оношлуурын 7,156,307.1 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, байгууллагын хэмжээнд тусламж үйлчилгээг хүртээмжтэй үзүүлэхэд удирдлага зохион байгуулалтаар хангах, албан хаагчид шууд харьяалан удирдуулах албан тушаалтны ажлыг хавсруулж, 46,336.2 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна.

612503465

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны 04 дугаар тогтоолоор "Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношны хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ"-нд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 10 зорилт, 72 арга хэмжээг хэрэгжүүлэхээр Эрүүл мэндийн сайдын төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулж, хэрэгжилтийг тайлант онд үнэлүүлээгүй байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР П.ПҮРЭВЛХАГВА

## ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **6,827,835,127.45** | **5,914,166,994.65** |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **997,175,293.65** | **157,497,297.97** |
| 312 | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **997,175,293.65** | **157,497,297.97** |
| 3121 | **Төгрөг** | **997,175,293.65** | **157,497,297.97** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 997,175,293.65 | 157,497,297.97 |
| 33 | **АВЛАГА** | **2,774,465,733.30** | **4,036,871,736.26** |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 2,774,465,733.30 | 4,036,871,736.26 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | **3,056,194,100.50** | **1,719,797,960.42** |
| 351 | **Түүхий эд материал** | **1,546,560,825.60** | **1,676,636,300.30** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 971,167,015.67 | 1,098,953,717.67 |
| 35130 | Эм боох материал | 575,393,809.93 | 577,682,582.63 |
| 354 | **Хангамжийн материал** | **1,509,633,274.90** | **43,161,660.12** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 0.00 | 2,785,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 0.00 | 236,816.80 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 5,411,136.90 | 3,666,683.32 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,486,694,633.00 | 0.00 |
| 35460 | Хүнсний материал | 12,990,500.00 | 25,939,060.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 4,537,005.00 | 10,533,900.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **31,790,559,649.52** | **33,793,655,365.05** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **31,790,559,649.52** | **33,793,655,365.05** |
| 392 | **Биет хөрөнгө** | **28,926,839,649.52** | **30,864,945,631.55** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 26,058,941,004.03 | 27,863,017,731.03 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -6,060,848,266.45 | -7,368,686,094.90 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 1,474,368,083.20 | 1,529,368,083.20 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -722,685,773.40 | -858,698,201.51 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 20,347,760,304.51 | 21,469,497,998.01 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -12,595,751,185.94 | -13,596,363,994.79 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 357,843,125.57 | 350,225,878.57 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -228,476,836.24 | -245,116,913.53 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 732,995,579.00 | 1,991,291,678.74 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -437,306,384.76 | -269,590,533.27 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | **2,863,720,000.00** | **2,928,709,733.50** |
| 39301 | Программ хангамж | 9,883,087.00 | 84,883,087.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -9,883,087.00 | -19,893,353.50 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2,863,720,000.00 | 2,863,720,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **38,618,394,776.97** | **39,707,822,359.70** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **3,379,201,282.29** | **7,155,307,068.23** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **3,379,201,282.29** | **7,155,307,068.23** |
| 413 | **Өглөг** | **3,379,201,282.29** | **7,155,307,068.23** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 217,117,447.30 | 1,851,525,842.18 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 2,761,606,099.99 | 4,433,917,089.55 |
| 4136 | Бусад өглөг | **400,477,735.00** | **869,864,136.50** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 398,719,735.00 | 845,024,136.50 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 1,758,000.00 | 24,840,000.00 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **35,239,193,494.68** | **32,552,515,291.47** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | **35,239,193,494.68** | **32,552,515,291.47** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 10,297,152,047.96 | 10,297,152,047.96 |
| 51101 | Өмч: - төрийн | 10,297,152,047.96 | 10,297,152,047.96 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | **5,040,196,890.26** | **2,353,518,687.05** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 7,606,186,482.03 | 5,040,196,890.26 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -2,565,989,591.77 | -2,686,678,203.21 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 19,901,844,556.46 | 19,901,844,556.46 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **38,618,394,776.97** | **39,707,822,359.70** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Балансын зүйл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **32,835,368,855.86** | **38,263,042,783.85** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **6,762,138,486.86** | **9,443,771,810.85** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | **6,762,138,486.86** | **9,443,771,810.85** |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 5,380,107,700.46 | 6,514,396,641.69 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 781,454,384.00 | 189,680,202.94 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,577,473,257.66 | 5,826,964,541.63 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- бараа материал | 1,021,180,058.80 | 497,751,897.12 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,382,030,786.40** | **2,929,375,169.16** |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө | 1,382,030,786.40 | 2,929,375,169.16 |
| 1340 | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **26,073,230,369.00** | **28,819,270,973.00** |
| 133002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | 26,073,230,369.00 | 28,819,270,973.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **35,401,358,447.63** | **40,949,720,987.06** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **35,401,358,447.63** | **40,949,720,987.06** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **34,863,644,101.38** | **40,155,597,540.76** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **18,550,879,062.94** | **22,415,526,634.15** |
| 210101 | Үндсэн цалин | 8,391,756,234.88 | 12,613,323,123.94 |
| 210102 | Нэмэгдэл | 8,476,266,838.20 | 8,686,679,837.28 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 894,482,768.62 | 727,763,311.45 |
| 210104 | Урамшуулал | 788,373,221.24 | 387,760,361.48 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **3,242,186,420.00** | **2,789,091,175.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,310,331,529.60 | 1,878,294,375.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 232,969,197.60 | 227,699,200.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгал | 131,128,878.08 | 113,849,600.00 |
| 210204 | Ажилгүйдлын даатгал | 101,851,319.52 | 113,849,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 465,905,495.20 | 455,398,400.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **905,705,053.74** | **932,033,353.70** |
| 210301 | Гэрэл цахилгаан | 382,682,658.37 | 493,097,106.20 |
| 210302 | Түлш, халаалт | 303,559,864.16 | 259,655,993.93 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 219,462,531.21 | 179,280,253.57 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **521,112,163.80** | **324,988,444.44** |
| 210401 | Бичиг хэрэг | 26,887,960.00 | 36,902,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 143,628,944.84 | 139,197,286.29 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 17,972,500.00 | 27,421,109.95 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 44,771,985.00 | 6,903,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 108,000,000.00 | 114,564,148.20 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 179,850,773.96 | 0.00 |
| 2105 | **Нормативт зардал** | **7,048,084,010.18** | **8,171,709,398.92** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 6,503,995,902.18 | 7,585,973,023.92 |
| 210502 | Хоол, Хүнс | 520,877,563.00 | 575,385,270.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 23,210,545.00 | 10,351,105.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,204,742,503.65** | **2,020,925,020.28** |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 0.00 | 4,800,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,204,742,503.65 | 2,016,125,020.28 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | **18,175,900.00** | **17,214,660.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 18,175,900.00 | 17,214,660.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **109,012,727.00** | **151,030,280.61** |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 27,169,887.00 | 69,630,253.11 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 962,640.00 | 1,291,327.50 |
| | Тээврийн хэрэгслийн даатгал | 7,000,000.00 | 7,000,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 495,000.00 | 594,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 13,000,000.00 | 10,145,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 22,885,200.00 | 30,150,400.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх бэлтгэх зардал | 37,500,000.00 | 32,219,300.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **3,263,746,260.07** | **3,333,275,205.63** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,061,957.64 | 35,028,143.00 |
| 210902 | Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх | 52,100,000.00 | 0.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал | 3,186,584,302.43 | 3,298,247,062.63 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **537,714,346.25** | **794,123,446.30** |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | **457,644,400.00** | **580,482,000.00** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 383,526,000.00 | 568,770,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 74,118,400.00 | 11,712,000.00 |
| 2134 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **80,069,946.25** | **213,641,446.30** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 80,069,946.25 | 213,641,446.30 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-2,565,989,591.77** | **-2,686,678,203.21** |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | -2,565,989,591.77 | -2,686,678,203.21 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 0 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 0.00 | 0.00 |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | 32,949,581,607.36 | 33,638,204,332.61 |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 853,454,384.00 | 1,499,807,802.94 |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 853,454,384.00 | 1,499,807,802.94 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 853,454,384.00 | 1,499,807,802.94 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 781,454,384.00 | 189,680,202.94 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 72,000,000.00 | 1,310,127,600.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 32,096,127,223.36 | 32,138,396,529.67 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 2,307,832,072.66 | 3,903,257,941.63 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 2,307,832,072.66 | 3,689,796,495.33 |
| 133 | Төсвийн ерөнхийлөн захирагчдаас | 1,197,641,185.00 | 602,739,000.00 |
| 133005 | Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт | 1,197,641,185.00 | 602,739,000.00 |
| 1340 | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 28,590,653,965.70 | 27,632,399,588.04 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 28,590,653,965.70 | 27,632,399,588.04 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | 32,180,115,011.20 | 34,477,882,328.29 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 32,180,115,011.20 | 34,264,420,882.46 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 31,639,894,664.95 | 34,050,959,436.16 |
| 2101 | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | 18,818,651,194.66 | 20,597,785,703.89 |
| 210101 | Үндсэн цалин | 8,659,528,366.60 | 9,094,009,726.43 |
| 210102 | Нэмэгдэл | 8,476,266,838.20 | 10,328,968,484.18 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 894,482,768.62 | 787,047,131.80 |
| 210104 | Урамшуулал | 788,373,221.24 | 387,760,361.48 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 3,242,186,420.00 | 2,789,091,175.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,310,331,529.60 | 1,878,294,375.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 232,969,197.60 | 227,699,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 131,128,878.08 | 113,849,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 101,851,319.52 | 113,849,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 465,905,495.20 | 455,398,400.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 994,650,063.70 | 932,033,353.70 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 418,371,710.37 | 493,097,106.20 |
| 210302 | Түлш, халаалт | 338,187,040.12 | 259,655,993.93 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 238,091,313.21 | 179,280,253.57 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 339,125,897.95 | 286,606,634.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 27,097,300.00 | 22,251,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 143,728,597.95 | 133,650,102.05 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 18,000,000.00 | 23,075,609.95 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 42,300,000.00 | 6,903,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 108,000,000.00 | 100,725,522.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 6,495,615,960.00 | 6,443,771,871.96 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 5,865,310,802.00 | 5,929,030,092.43 |
| 210502 | Хоол, хүнс | 596,780,908.00 | 487,416,779.53 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 33,524,250.00 | 27,325,000.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,524,881,549.00 | 2,147,645,669.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 921,239,700.00 | 701,355,780.00 |
| 210604 | Урсгал засвар | 603,641,849.00 | 1,446,289,889.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 18,175,900.00 | 17,214,660.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 18,175,900.00 | 17,214,660.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 114,982,927.00 | 221,085,980.14 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 40,405,287.00 | 69,630,253.11 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 7,000,000.00 | 7,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 962,640.00 | 1,291,327.50 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 495,000.00 | 594,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 13,000,000.00 | 89,920,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 15,620,000.00 | 30,150,400.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 37,500,000.00 | 22,500,000.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 91,624,752.64 | 42,542,388.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 39,524,752.64 | 42,542,388.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 52,100,000.00 | 0.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 540,220,346.25 | 573,182,000.00 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 460,150,400.00 | 573,182,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтэй ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 383,526,000.00 | 568,770,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 76,624,400.00 | 4,412,000.00 |
| 2134 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 80,069,946.25 | 213,461,446.30 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 80,069,946.25 | 213,461,446.30 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ | 219,000,000.00 | |
| | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 219,000,000.00 | |
| | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 219,000,000.00 | |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | -219,000,000.00 | |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | -219,000,000.00 | |
| | Бусад зардал | -219,000,000.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 769,466,596.16 | -839,677,996.15 |
| 250001 | Гадаад валютын ханшийн зөрүү | 0.00 | 0.00 |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 769,466,596.16 | -839,677,996.15 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 227,708,697.49 | 997,175,293.65 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 997,175,293.65 | 157,497,297.97 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 10,297,152,047.96 | 19,901,844,556.46 | 7,420,285,484.93 | 37,805,183,086.45 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 185,900,997.10 | 185,900,997.10 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 10,297,152,047.96 | 19,901,844,556.46 | 7,606,186,482.03 | 37,805,183,086.45 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -2,565,989,591.77 | -2,565,989,591.77 |
| C08 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 10,297,152,047.96 | 19,901,844,556.46 | 5,040,196,890.26 | 35,239,193,494.68 |
| D01 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -2,686,678,203.21 | -2,686,678,203.21 |
| D09 | 2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 10,297,152,047.96 | 19,901,844,556.46 | 2,353,518,687.05 | 32,552,515,291.47 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 997,175,293.65 | -997,175,293.65 | |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 42,251,266,200.00 | 34,264,420,882.46 | 7,986,845,317.54 | 81.10 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 42,251,266,200.00 | 34,264,420,882.46 | 7,986,845,317.54 | 81.10 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 41,068,456,200.00 | 34,050,959,436.16 | 7,017,496,763.84 | 82.91 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 22,981,013,700.00 | 20,597,785,703.89 | 2,383,227,996.11 | 89.63 |
| Үндсэн цалин | 11,359,677,300.00 | 9,094,009,726.43 | 2,265,667,573.57 | 80.06 |
| Нэмэгдэл | 9,044,481,900.00 | 10,328,968,484.18 | -1,284,486,584.18 | 114.20 |
| Унаа хоолны Хөнгөлөлт | 1,286,977,900.00 | 787,047,131.80 | 499,930,768.20 | 61.15 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Урамшуулал | 1,289,876,600.00 | 387,760,361.48 | 902,116,238.52 | 30.06 |
| Гэрээт ажлын хөлс | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 2,907,695,500.00 | 2,789,091,175.00 | 118,604,325.00 | 95.92 |
| Тэтгэврийн даатгал | 1,960,739,300.00 | 1,878,294,375.00 | 82,444,925.00 | 95.80 |
| Тэтгэмжийн даатгал | 236,739,100.00 | 227,699,200.00 | 9,039,900.00 | 96.18 |
| ҮОМШӨ-ний даатгал | 118,369,500.00 | 113,849,600.00 | 4,519,900.00 | 96.18 |
| Ажилгүйдлийн даатгал | 118,369,500.00 | 113,849,600.00 | 4,519,900.00 | 96.18 |
| Эрүүл мэндийн даатгал | 473,478,100.00 | 455,398,400.00 | 18,079,700.00 | 96.18 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,145,494,800.00 | 932,033,353.70 | 213,461,446.30 | 0.00 |
| Гэрэл, цахилгаан | 487,291,500.00 | 493,097,106.20 | -5,805,606.20 | 101.19 |
| Түлш, халаалт | 399,186,300.00 | 259,655,993.93 | 139,530,306.07 | 65.05 |
| Цэвэр, бохир ус | 259,017,000.00 | 179,280,253.57 | 79,736,746.43 | 69.22 |
| Байрны түрээс | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Хангамж, бараа материалын зардал | 347,182,300.00 | 286,238,242.00 | 60,944,058.00 | 82.45 |
| Бичиг хэрэг | 26,751,200.00 | 22,251,900.00 | 4,499,300.00 | 83.18 |
| Тээвэр, шатахуун | 151,672,500.00 | 133,650,102.05 | 18,022,397.95 | 88.12 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 27,097,400.00 | 23,075,609.95 | 4,021,790.05 | 85.16 |
| Ном, хэвлэл | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 18,135,200.00 | 6,903,500.00 | 11,231,700.00 | 38.07 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 123,526,000.00 | 100,725,522.00 | 22,800,478.00 | 81.54 |
| Нормативт зардал | 6,677,716,400.00 | 6,443,771,871.96 | 233,944,528.04 | 96.50 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 6,137,757,900.00 | 5,927,006,092.43 | 210,751,807.57 | 96.57 |
| Хоол, хүнс | 504,458,500.00 | 500,280,779.53 | 4,177,720.47 | 99.17 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 35,500,000.00 | 27,325,000.00 | 8,175,000.00 | 76.97 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 2,043,590,800.00 | 2,147,645,669.00 | -104,054,869.00 | 105.09 |
| Багаж, техник, хэрэгсэл | 676,837,000.00 | 701,355,780.00 | -24,518,780.00 | 103.62 |
| Тавилга | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Урсгал засвар | 1,366,753,800.00 | 1,446,289,889.00 | -79,536,089.00 | 105.82 |
| Томилолт, зочны зардал | 24,260,200.00 | 17,214,660.00 | 7,045,540.00 | 70.96 |
| Гадаад албан томилолт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Дотоод албан томилолт | 24,260,200.00 | 17,214,660.00 | 7,045,540.00 | 70.96 |
| Зочин төлөөлөгч хүлээн авах | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 345,931,300.00 | 216,207,005.61 | 129,724,294.39 | 62.50 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 188,151,300.00 | 69,630,253.11 | 118,521,046.89 | 37.01 |
| Даатгалын үйлчилгээ | 7,000,000.00 | 7,000,000.00 | 0.00 | 100.00 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 3,350,000.00 | 1,291,327.50 | 2,058,672.50 | 38.55 |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 3,400,000.00 | 594,000.00 | 2,806,000.00 | 17.47 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 90,600,000.00 | 89,920,000.00 | 680,000.00 | 99.25 |
| Газрын төлбөр | 30,930,000.00 | 25,271,425.00 | 5,658,575.00 | 81.71 |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 22,500,000.00 | 22,500,000.00 | 0.00 | 100.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 5,741,066,000.00 | 42,542,388.00 | 5,698,523,612.00 | 0.74 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 5,741,066,000.00 | 42,542,388.00 | 5,698,523,612.00 | 0.74 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,182,810,000.00 | 573,182,000.00 | 609,628,000.00 | 48.46 |
| Бусад урсгал шилжүүлэг | 1,182,810,000.00 | 573,182,000.00 | 609,628,000.00 | 48.46 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 599,040,000.00 | 0.00 | 599,040,000.00 | 0.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 568,770,000.00 | 568,770,000.00 | 0.00 | 100.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 15,000,000.00 | 4,412,000.00 | 10,588,000.00 | 29.41 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 42,251,266,200.00 | 32,822,003,886.31 | 9,429,262,313.69 | 77.68 |
| ТӨСВИЙН ЗАХИРАГЧААС | 602,739,000.00 | 602,739,000.00 | 0.00 | 100.00 |
| Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн | 602,739,000.00 | 602,739,000.00 | 0.00 | 100.00 |
| ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,683,000,000.00 | 3,689,796,495.33 | -1,006,796,495.33 | 137.53 |
| Орон нутгийн төсвөөс | 2,683,000,000.00 | 3,689,796,495.33 | -1,006,796,495.33 | 137.53 |
| ЭМД-ААС САНХҮҮЖИХ | 36,864,148,100.00 | 27,632,399,588.04 | 9,231,748,511.96 | 74.96 |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 36,864,148,100.00 | 27,632,399,588.04 | 9,231,748,511.96 | 74.96 |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 2,704,118,100.00 | 1,499,807,802.94 | 1,204,310,297.06 | 0.00 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 396,513,000.00 | 189,680,202.94 | 206,832,797.06 | 47.84 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,310,127,600.00 | 1,310,127,600.00 | 0.00 | 100.00 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 997,175,293.65 | 0.00 | 997,175,293.65 | 0.00 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 157,497,297.50 | -157,497,297.50 | 0.00 |

Аудитаар нийт 6,331,217.0 мянган төгрөгийн 11 алдаа[1] илэрснээс аудитын явцад 6,331,217.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

***Залруулсан алдаа:***

- ✓ Санхүүгийн байдлын тайланд бараа материалын эцсийн үлдэгдлийг 3,287.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,
- ✓ Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлангийн тайлант оны үр дүнг 3,295,222.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,
- ✓ Тайлант онд үүссэн нийгмийн даатгалын шимтгэлийн 56,030.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг санхүүгийн тайланд тайлагнаагүй,
- ✓ Санхүүгийн байдлын тайлангийн нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл нь өглөгийн тодруулга тайлантай 773,470.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,
- ✓ Санхүүгийн үр дүнгийн тайланд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад Төрөөс үзүүлэх дэмжлэгийн зардлыг 8,505.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,
- ✓ Тайлант онд ХӨСҮТ-өөс үнэ төлбөргүй ирсэн 12 нэр төрлийн 27,739.0 мянган төгрөгийн лабораторийн оношилгооны хэрэгсэл бараа материалыг санхүүгийн тайланд орлогоор тусгаагүй.
- ✓ Өмнөх оны аудитын тайлангаас санхүүгийн тайлангийн ажилчидтай холбогдсон өглөгийн эхний үлдэгдлийг 44,509,7 мянган төгрөгийн өглөгийг зөрүүтэй тайлагнасан,
- ✓ Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн үйл ажиллагааны орлого 37,825.6 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 67,979.7 мянган төгрөгийг ерөнхий журналын дүнгээс зөрүүтэй тайлагнасан,
- ✓ Санхүүгийн үр дүнгийн тайлан, бараа материалын тодруулга тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлогыг 9,087.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,
- ✓ Санхүүгийн үр дүнгийн тайланд орон нутгийн урсгал санхүүжилтийг 1,075,527.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,
- ✓ Санхүүгийн үр дүнгийн тайланд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын 932,033.3 мянган төгрөгийн зардлыг тайлагнаагүй нь УСНББОУС 1 болон толилуулга батламж мэдэгдлүүдийг хангаагүй тул санхүүгийн тайлангийн аудитаар залруулав.

Аудитаар нийт 82,482.2 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 7,434.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 46,336.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 28,712.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

Тайлант онд 1 албан хаагчид хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг тушаал шийдвэргүй, мөнгөн тэтгэмж авах эрх үүсээгүй байхад 7,434.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

### 3.2 Албан шаардлага

Тайлант онд удирдах 9 албан хаагчид шууд харьяалан удирдуулах албан тушаалтны ажлыг хавсруулж, 46,336.2 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. Мөн байгууллагын санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад хуулийн хугацаанд ирүүлээгүй, санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд хангалттай, зохистой

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

аудитын нотолгоог олж авах цаг хугацааны хязгаарлалтад оруулсан ерөнхий нягтлан бодогч Н.Ариунзаяад хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

**3.3 Зөвлөмж:**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Авлагын данстай холбоотой асуудал**

***Илрүүлэлт:***

Эрүүл хүүхэд аяны санхүүжилтийн 23,814.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ", 20.2.6-т "бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т заасан "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг зөрчсөн байна.Ө Эрүүл хүүхэд аяны санхүүжилтийн 23,814.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ", 20.2.6-т "бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т заасан "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Авлагыг барагдуулах талаар холбогдох байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлэх.

2. **Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал**

***Илрүүлэлт*:**

Тус байгууллага нь 2013 онд Мишээл-Од Аудит" ХХК-ийн боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байгаа боловч чанар гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэн тул "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн батлуулж, мөрдөж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасныг зөрчсөн байна

***Өгсөн зөвлөмж*:**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталж, мөрдөж ажиллах.

3. **Дотоод хяналт, хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

***Илрүүлэлт*:**

Байгууллагын санхүү бүртгэлийн албаны даргыг томилоход сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй, албан тушаалаас чөлөөлөхөд ажил хүлээлцэх комисс томилоогүй, эд хөрөнгийн тооллого хийгээгүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй" "Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах

захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.2-т " эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед 12.3-т "Төрийн өмчийн хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хуульд заасан хугацаанд болон зайлшгүй шаардлагатай үед хийнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Ө***гсөн зөвлөмж***:

Байгууллагын санхүү бүртгэлийн ажилтан солигдох үед шийдвэр гаргаж, эд хөрөнгийн тооллогыг хийж хэвших.

**4. Цалингийн зардалтай холбоотой асуудал**

***Илрүүлэлт***:

Эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ үзүүлсэн албан хаагчид олгох 4,898.0 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг жилийн эцсийн санхүүгийн тайландаа өглөгөөр бүртгэлгүй, төсвийн жил дамнуулан дараа жилийн төсвөөс зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 7.1-д "Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"; гэж заасныг зөрчсөн байна.

**Ө*гсөн зөвлөмж***:

Өмнөх онд гарсан шийдвэрийг үндэслэн төсвийн жил дамнуулан зардал гаргахгүй байх.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

.Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн байдлын тайланд бараа материалын эцсийн үлдэгдлийг 3,287.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан | 1 | 3,287.4 | | | 1 | 3,287.4 | 1 | 3,287.4 | | | | |
| Санхүүгийн үр дүнгийн тайланд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийн зардлыг 8,505.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан | 1 | 8,505.0 | | | 1 | 8,505.0 | 1 | 8,505.0 | | | | |
| Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлангийн тайлант оны үр дүнг 3,295,222.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан | 1 | 3,295,222.1 | | | 1 | 3,295,222.1 | 1 | 3,295,222.1 | | | | |
| Тайлант онд үүссэн нийгмийн даатгалын шимтгэлийн 56,030.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг санхүүгийн тайланд тайлагнаагүй. | 1 | 56,030.5 | | | 1 | 56,030.5 | 1 | 56,030.5 | | | | |
| Санхүүгийн байдлын тайлангийн нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл нь өглөгийн тодруулга тайлантай 773,470.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. | 1 | 773,470.0 | | | 1 | 773,470.0 | 1 | 773,470.0 | | | | |
| Тайлант онд ХӨСҮТөвөөс үнэ төлбөргүй ирсэн 12 нэр төрлийн 27,739.0 мянган төгрөгийн лабораторийн оношилгооны хэрэгсэл бараа материалыг санхүүгийн тайланд орлогоор тусгаагүй. | 1 | 27,739.0 | | | 1 | 27,739.0 | 1 | 27,739.0 | | | | |
| Өмнөх оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн ажилчидтай холбогдсон өглөгийн эхний үлдэгдлийг 44,509,7 | 1 | 44,509.7 | | | 1 | 44,509.7 | 1 | 44,509.7 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| мянган төгрөгийн өглөгийг зөрүүтэй тайлагнасан | | | | | | | | | | | | |
| Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн үйл ажиллагааны орлого 37,825.6 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 67,979.7 мянган төгрөгийг ерөнхий журналын дүнгээс зөрүүтэй тайлагнасан | 1 | 105,805.3 | | | 1 | 105,805.3 | 1 | 105,805.3 | | | | |
| Санхүүгийн үр дүнгийн тайлан, бараа материалын тодруулга тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлогыг 9,087.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан | 1 | 9,087.6 | | | 1 | 9,087.6 | 1 | 9,087.6 | | | | |
| Санхүүгийн үр дүнгийн тайланд орон нутгийн урсгал санхүүжилтийг 1,075,527.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. | 1 | 1,075,527.1 | | | 1 | 1,075,527.1 | 1 | 1,075,527.1 | | | | |
| Санхүүгийн үр дүнгийн тайланд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын 932,033.3 мянган төгрөгийн зардлыг тайлагнаагүй алдааг залруулан бүртгэсэн. | 1 | 932,033.3 | | | 1 | 932,033.3 | 1 | 932,033.3 | | | | |
| **Дүн** | **11** | **6,331,217.0** | | | **11** | **6,331,217.0** | **11** | **6,331,217.0** | | | | |

**ТАВ. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо |
| Тайлант онд 1 албан хаагчид хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласаны тэтгэмжийг тушаал шийдвэргүй, мөнгөн тэтгэмж авах эрх үүсээгүй байхад 7,434.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон | 1 | 7,434.0 | 1 | 7,434.0 | | | | | | |
| Тайлант онд удирдах 9 албан хаагчид шууд харьяалан удирдуулах албан тушаалтны ажлыг хавсруулж 46,336.2 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон | 1 | 46,336.2 | | | 1 | 46,336.2 | | | | |
| Орхон аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төв нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдөр 77 дугаартай албан бичгийн хамт ирүүлсэн боловч санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг, | 1 | | | | | | | | 1 | 1 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| уялдаа холбоо, төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох хууль, журмын дагуу иж бүрэн бэлтгээгүй, санхүүгийн тайлагналын олон улсын стандарт", санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг", "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Хэмжилт", "Тасалбар болголт" батламж мэдэгдлүүдийг хангахгүй, санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах цаг хугацааг хязгаарлаж байна. | | | | | | | | | | |
| Эрүүл хүүхэд аяны санхүүжилтийн 23,814.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна | 1 | | | | | | 1 | 23,814.0 | | |
| Тус байгууллага нь 2013 онд Мишээл-Од Аудит" ХХК-ийн боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байгаа боловч чанар гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэн тул "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталуулж мөрдөж ажиллаагүй | 1 | | | | | | 1 | 0 | | |
| Эмнэлэгийн яаралтай тусламж үйлчилгээ үзүүлсэн албан хаагчид 4,898.0 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг тайлант онд олгоогүй | 1 | | | | | | 1 | 4,898.0 | | |
| Байгууллагын санхүү бүртгэлийн албаны даргыг албан тушаалаас чөлөөлөхөд ажил хүлээлцэх комисс томилоогүй, эд хөрөнгийн тооллого хийгээгүй байна. | 1 | | | | | | 1 | 0 | | |
| Дүн | **7** | **50,109.4** | **1** | **7,434.0** | **1** | **46,336.2** | **4** | **28,712.0** | **1** | **1** |